



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/255

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "г", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь хэсгүүд, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хийх, гэрээ дүгнэх, гүйцэтгэл хүлээн авах, ашиглалтад оруулах ажиллагааг зохион байгуулахад Орон нутгийн өмчийн газарт шаардлагатай 2429,0 мянган төгрөгийн зардлын нэр төрөл, ангиллыг хавсралтаар баталсугай.

2. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гэрээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай 2429,0 мянган төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд)-д даалгасугай.

3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт тавих, гэрээ дүгнэх, гүйцэтгэл хүлээн авах, ашиглалтад оруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, тухайн жилийн дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тайлагнахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Л. ГАНБОЛД



d/zahiramj

01110594